



Г

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ  
Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatrural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2025.06.27 № 25

Г Монголбанкнаас арилжааны банканд  
тавих хяналтын талаар

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;” гэж, мөн хэсгийн 7 дахь заалтад “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж Монголбанкны хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор дараах асуултыг Танд хүргүүлж байна. Үүнд:

1. Арилжааны банкнаас иргэн, хуулийн этгээдэд олгож буй зээлийн бодит өртгийн бүтэц, өртгийг хэрхэн, ямар аргачлал, журам, хууль тогтоомжийн дагуу тогтоож байгаа мэдээллийг зээлийн бүтээгдэхүүний төрөл тус бүрээр, түүнчлэн зээлийн хүүгээс бусад зээлийн өртөг болох шимтгэл, хураамжийг тогтоодог болон тогтоодоггүй зээлийн бүтээгдэхүүний талаарх мэдээлэл, шимтгэл, хураамжийг тогтоодог үндэслэл, шимтгэл, хураамжтай холбоотой зээлдэгч, хэрэглэгчийн ирүүлдэг гомдлын агуулга, тоо /сүүлийн таван жилээр/, энэ чиглэлээрх хэрэглэгчийг хамгаалах Монгол Улсын Төв банк /Монголбанк/-ны бодлогын талаарх мэдээлэл;

2. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу хадгаламжид тооцсон хүүгийн орлогод ногдуулж буй татварын банкны салбар болон зээлийн бодит өртөгт нөлөөлж буй эерэг нөлөө, сөрөг үр дагаврыг тооцсон судалгаа, мэдээлэл;

3. Арилжааны банк дахь иргэдийн хугацаатай хадгаламжийн хугацааны дундаж буюу тэдгээрийн хэдэн хувь нь богино хугацаатай /1 жил хүртэлх/, хэдэн хувь нь 5 жил хүртэлх, хэдэн хувь нь 5, түүнээс дээш жилийн хугацаатай хадгаламж байдаг талаарх мэдээлэл;

4. Арилжааны банкнаас банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, ломбард буюу барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд олгосон зээлийн хэмжээ, давтамж, тэдгээрийн эргэн төлөлтийн талаарх сүүлийн 5 жилийн мэдээлэл.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

П.САЙНЗОРИГ

2025000034